

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2021.05.05 № 1407

танай -ны № -т

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд оролцоо нэр дэвшигчээс ирүүлсэн мөрийн хөтөлбөрийг холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагад нийцсэн эсэхийг хяналаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд оролцох нэр дэвшигч нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцүүлэн сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг Төрийн аудитын байгууллагад ирүүлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Үндэсний аудитын газар нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд оролцох нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль тогтоомж холбогдох бусад баримтыг тус тус шалгуур болгон авч үзсэн.

## Дүгнэлт

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд нэр дэвшигч Содномзундуйн Эрдэнийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2, 33.4. дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлага, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтооолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тус тус нийцсэн байна.

Мөрийн хөтөлбөр /.....14..... хуудас/-ийг хавсаргав.

Хүндэтгэсэн,



Д.ЗАНДАНБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
2021 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД  
АРДЧИЛСАН НАМААС НЭР ДЭВШИГЧ  
СОДНОМЗУНДУЙН ЭРДЭНИЙН  
“ХУВЬ ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН  
АРДЧИЛСАН МОНГОЛ”  
МОРИЙН ХӨТОЛБОР

**Улаанбаатар хот**

**2021**


09999944

Монгол Улсын тусгаар тогтнол, улс эх орны язгуур эрх ашиг, Үндсэн хуултын ардчилал, парламенттэй ёсоо хамгаалан бэхжүүлж, Монгол хүний эрх чөлөө, хууль дээдлэх засаглал, чөлөөт зах зээл, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, иргэний нийгмийн зарчимд суурилсан хурдацтай хөгжлийн төлөө зүтгэх Ерөнхийлөгч байна.

Сайн хөршийн найрсаг харилцааг гүнзгийрүүлэхийн зэрэгцээ гуравдагч хөрш рүү чиглэсэн эрчимтэй гадаад бодлоготой ардчилсан Монгол Улсаа сэргээн мандуулахыг ЭРХЭМ ЗОРИЛГО болгож,

- Монгол Улсын язгуур эрх ашиг;
- Монгол хүний эрх, эрх чөлөө;
- Хувийн өмч, эдийн засгийн эрх чөлөө;
- Хуулийн дээдлэх засаглал, шударга төрийг бэхжүүлэхийг тунхаглан

Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд оролцох “ХУВЬ ХУНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН АРДЧИЛСАН МОНГОЛ” мөрийн хөтөлбөрөө толилуулж байна.



## НЭГ. ҮНДЭСНИЙ ЭВ НЭГДЭЛ-АРДЧИЛСАН ТӨР

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 1-д Монгол Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн бөгөөд үндэсний эв нэгдлийг илэрхийлэгч мөн гэж заасан, болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан “Төрийн байгуулал, улс орны удирдлагын талаарх Ерөнхийлөгчийн бүрэн эрх”-ийн хүрээнд дараах мөрийн хөтөлбөрийг дэвшүүлж байна. Үүнд:

Иргэн бүр хуулийн өмнө эрх тэгш байх, улс эх орондоо эрх чөлөөтэй амьдрах зарчим, үзэл баримтлалын хүрээнд Монгол Улсын хууль, төрийн эрх мэдэл дарга нарт бус, иргэдэд зориулагдсан, иргэдэд үйлчилдэг байх, төрийн эрх хэмжээг хязгаарлаж харин иргэний эрхийг улам бүр нэмэгдүүлэх чиглэлийн олон талын үйл ажиллагааг хэрэгжүүлж, дэмжих зорилготой Монгол хүн төвтэй нийгэм бүтээхийн төлөө гол анхаарлаа хандуулна.

Эрх мэдэл, мэдээлэлд ойрхон давуу талаас үүдэлтэй төр төвтэй “дарга анги”-нэгэнт үүсэн бэхжээд байна. Энэ гажуудал нь нийгмийн талцал, хуваагдлыг гүнзгийрүүлж, нийгмийн баялгийн шударга бус хуваарилалтыг өөгшүүлж, улмаар үндэсний эв нэгдэлд сөрөг нөлөө үзүүлэхүйц хэмжээнд хүрч буйг харгалzan иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалж, Монгол хүний эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэх, Монгол хүн төвтэй төрийн хөгжлийг дэмжин, төрийн авилгаас ангид ажиллах чадавхтай хяналт, шалгалт, зөвшөөрлийн тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр шинэчлэлийг санаачилна.

Иргэн бүр эрхэлж буй ажил, албан тушаал, нийгмийн байдал, хөрөнгө мөнгөний хэмжээнээсээ үл хамаарч хуулийн өмнө тэгш эрхтэй байх, хариуцлагыг шударгаар хүлээлгэдэг шударга шүүхийн тогтолцоог бүрдүүлэх шинэтгэлийг тууштай үргэлжлүүлнэ. Үндсэн хуулийн хүрээнд Шүүх байгуулах тухай хуулийг шинэчилж, сахилга хариуцлага алддаг, ёс зүйгүй, өргөсөн тангаргаа зөрчдөг шударга бус, шүүгчдийг огцуулж, бусдыгаа манлайлдаг, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг тууштай хамгаалагч, ёс зүй, харилцаа, хандлага, хүнлэг байдлын хувьд өндөр түвшинд хүрсэн хуульчдыг шударга өрсөлдөөнөөр шүүгчээр томилоо бодлого баримтална.

Торгодог, шийтгэдэг бус дэмждэг, зөвлөдөг, урьдчилан сануулдаг, хамтран ажилладаг ардчилсан төрийн соёлыг түгээн дэлгэрүүлнэ.

Хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын албан тушаалтны ёс зүй, зан харилцаа, хандлага, шударга байдал, тавих олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгох эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.

Шүүгчийн хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор шүүхийн ил тод, нээлттэй байдлыг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулах, шударга ёсыг хангах үүднээс шүүх хуралдаан олон нийтэд нээлттэй байх зарчмыг хөхиулэн дэмжинэ.

Прокурор байгууллагын удирдлагын тогтолцоо нь захирах, захирагдах ёсонд тулгуурлаж байгаа нь хүний эрх, эрх чөлөөнд ноцтой заналхийлж, бусдыг хэлмэгдүүлэх,

хонгилын гэх хууль хяналтын байгууллагын зүй бус тогтолцоо үүсэх нөхцөл гэж үзэн прокурорын хараат бус, бие даасан байдлыг хангах эрх зүйн орчин бүрдүүлэхийг зорино.

Иргэддээ итгэж, анхан шатны нэгж дээрээ асуудлаа шийдвэрлэх зарчмыг нутгийн удирдлагад бэхжүүлэх, хот, тосгоны эрх зүйн байдлыг тодорхой болгох зарчим баримталж, орон нутгийн эрх мэдэл, төсвийн боломжуудыг нэмэгдүүлэх санал, санаачилгыг дэмжинэ. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу Эрдэнэт, Дарханыг нэн яаралтай улсын чанартай хотын статус олгох асуудалд анхаарч ажиллана.

Үндэсний эв нэгдлийг дээдэлж, Ардчилсан Үндсэн хуулийн үзэл санааг хотгээн дэлгэрүүлж, хэрэгжүүлж ажиллана.

Улсын Их Хурал - Засгийн газар - иргэний нийгмийн байгууллага - иргэн хоорондын хамтын ажиллагааг шинэ түвшинд хүргэж, худал улс төржилт, намчирхал, хийрхэл нь үндэсний эв нэгдэлд ноцтой хохирол учруулах, нийгмийг хуваагдалд хүргэх аюултай гэсэн үзэл санааны хүрээнд эрүүл бус аливаа талцалыг эсрэг зогсож, таслан зогсоох дорвитой ажлуудыг санаачилна.

Ардчилсан төрийн үйл ажиллагааны залгамж чанар, тогтвортой бодлогыг дэмжих чиглэлээр ажиллана. Монгол Улсын богино, дунд, урт, хугацааны бодлогын баримт бичгийг тууштай дэмжин ажиллаж, тухайлсан салбарт төрөөс баримтлах бодлогыг санаачлан, дэмжих чиглэлээр тодорхой ажлууд төлөвлөнө.

Төрийн тэргүүний хувьд хууль санаачлах бүрэн эрхээ хэрэгжүүлэх хүрээнд , иргэн, иргэний нийгмийн байгууллага, хуулийн этгээдтэй хамтран ажиллаж, тэдгээрээс гаргасан хөгжлийн талаарх аливаа санал, санаачилгыг хүлээн авч, дэмжин ажиллана.

Нэг нам, олонхоор хүч турэмгийлж, Монгол Улсын язгуур эрх ашиг, Монгол хүний эрх, эрх чөлөөний эсрэг аливаа дэглэмийг үл тэвчиж, төрийн Тэргүүний хувьд Улсын Их Хурлаар хэлэлцэгдэж байгаа хуулийн төсөл, бодлогын асуудлуудад байнгын хараа хяналт тавьж, саналаа ил тодор илэрхийлж, олон нийтээр хэлэлцүүлж, олон нийтийн болон улс орны ашиг сонирхол, төрийн байгууллын засаглалын зарчим, хуульд нийцээгүй, хүний эрх, эрх чөлөө, ардчилал, шударга ёсонд харшилсан хууль тогтоомжид хориг тавьж ажиллана.

Улсын Их Хурлын чуулган, Засгийн газрын хуралдаанд сар бүр тогтмол оролцож, нийт иргэдэд Монгол хүний эрхийн нөхцөл байдал, улс орны дотоод, гадаад байдлын нэн чухал асуудлаар мэдээлж, Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд хамаарах төрийн бодлогын асуудлаар Улсын Их Хурал, Засгийн газарт санал оруулах бөгөөд шаардлагатай тохиолдолд улс орны чанартай хойшлуулшгүй чухал асуудлыг хэлэлцүүлэхээр Улсын Их Хурлын ээлжит бус чуулган чуулахыг санаачилна.

Сонгогдсон, томилогдсон төрийн өндөр албан тушаалтан нь ёс зүйн зөрчил гаргасан бол олон нийтээс учлал гүйх үүргийг хуульчилж, түүнийг огцруулах, чөлөөлөх хууль эрх зүйн үндэслэлийг тодорхой болгох бие даасан хууль санаачилна.

Үндсэн хуулийн үзэл санааг хамгаалж, парламентын ардчиллыг төгөлдөржүүлэх боломжит бүх алхмуудыг хийнэ.

## ХОЁР. МОНГОЛ ХҮН-МОНГОЛ УГСААТАН

Монгол төрийн бодлогын цөм нь Монгол хүн байх ёстой. Тиймээс Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдуугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.” гэж заасан бүрэн эрхийн хүрээнд дараах мөрийн хөтөлбөрийг дэвшүүлж байна. **Үндсэн хуулийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.” гэж заасан бүрэн эрхийн хүрээнд дараах мөрийн хөтөлбөрийг дэвшүүлж байна.**



Хүний эрх, эрх чөлөөг хамгаалагч Ерөнхийлөгч байна.

Дэлхийд ижилгүй нүүдлийн соёлыг тээж буй Монгол угсаатны түүх, соёлыг олон улсад сурталчлан түгээхэд онцгой анхаарна. Нүүдлийн соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсын зах зээлд гаргах ажлыг хуулийн хүрээнд, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэний нийгмийн байгууллага, гадаадын байгууллагуудтай хамтран ажиллах замаар хөхиүүлэн урамшуулна.

Монгол Улсын иргэн болон дэлхийн олон улсад амьдарч байгаа Монгол угсаатан, тэдний үр хүүхдүүдэд олон улсын гэрээ, хуулиар олгогдсон бүхий л эрхийг хамгаалах бодлогыг хэрэгжүүлнэ. Дэлхийн Монголчуудыг Монгол үндэстний хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах нөөц бололцоо гэсэн үзэл санааны дагуу, тэднийг дэмжих, хамтран ажиллах бодлого хэрэгжүүлнэ.

Монгол хүн монголдоо хүссэн цагтаа саадгүй ирэх, ажиллах амьдрах, сурч боловсрох таатай нөхцөл бүрдүүлэхийн төлөө ажиллана.

Монгол Улсын иргэн бус монгол хүнд харьяатын иргэншил авах асуудлаар онцгой анхаарна. Гадаад улсад ажиллаж амьдарч байгаа мөн эцэг, эх нь монгол гаралтай монгол хүн бүрийн эрх, эрх чөлөө, эрх ашгийг анхаарч, дэмжлэг үзүүлж ажиллана.

Өөр хэл бүхий үндэстний цөөнх эх хэлээрээ суралцах, харилцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрх ашгийг дэмжин хамгаална.

Үндэсний боловсон хүчинээ бэлтгэхэд анхаарна. Өнөөдөр бэлдсэн үндэсний боловсон хүчин бол бидний ирээдүйг тодорхойлно. Иймээс хүүхэд бүрийг хөгжүүлж, бүтээлч, шинжлэх ухаанч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, Монгол орныхоо байгаль, түүх, үндэсний хэл соёл, уламжлалаараа бахархдаг, ёс суртахуунтай, зөв харилцаа, хандлагатай, хүнлэг сэтгэлтэй болгон хүмүүжил олгох “Зөв Монгол хүүхэд” хөтөлбөрийг дэмжинэ.

Жендерт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхал, бэлгийн дарамтыг арилгах санаачилга, манлайллыг дэмжинэ.

Хилийн чанадад ажиллаж, амьдарч буй иргэдийн нийтмийн баталгааг хангах зорилгоор улс орнуудтай нийгмийн хамгааллын талаар хамтран ажиллана.

Уламжлалт өв соёлоо төрийн бодлогоор дэмжин, боловсролын хөтөлбөрт тусгаж, монгол хүнийг төлөвшүүлэхэд онцгойлон анхаарна.

Дэлхий дахинд тархан суугаа монгол туургатны хэлхээ холбоо, хамтын ажиллагааг гүнзгийрүүлнэ.

Урлаг, спортын олон улсын хэмжээний томоохон арга хэмжээ, фестиваль, уралдаан, тэмцээнийг зохион байгуулахад Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс бүхий л талын дэмжлэг үзүүлнэ.

Монгол үндэстний баялаг түүхээс сэдэвлэсэн кино, уран бүтээл, контентуудыг бүтээх, түгээх, сурталчлах аливаа санаачилгыг дэмжинэ.

Ажиллах хүчийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, ажлын байр олноор бий болгохыг нэн тэргүүний зорилт гэж үзэн зуун мянган шинэ ажлын байрыг бий болгох бүтээн байгуулалт, бизнесийн төсөл, хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжих, хамгаалах бодлогыг хэрэгжүүлж ажиллана.

Хувьцаатай иргэн төслийг санаачилж, Төрийн өмчит аж ахуйн нэгжийг нээлттэй хувьцаат компани болгон биржээр иргэддээ хувьчилж /зах зээлийн үнээр худалдах/, хувьцааг нээлттэй худалдаалж ил тод, нээлттэй засаглалыг нэвтрүүлнэ. Эрдэнэт, Оюутолгой зэрэг стратегийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжийн 10-аас доошгүй хувийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулж иргэдэд хувьчлах /худалдах/ хуулийг санаачилна.

Нийгмийн даатгалын нэрийн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх, нийгмийн даатгалын өр төлбөрөө шат дараатайгаар бүрдүүлэх нөхцөлийг Засгийн газраас шаардана.

Хүүхэд хамгаалалт, түүнтэй холбоотой өдөр тутмын хяналтыг сайжруулах чиглэлээр үүрэг, чиглэл өгч ажиллана. Хүүхэд хамгааллын чиглэлээр төрийн үйлчилгээний санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд тэр, хувийн хэвшил, иргэний байгууллагуудтай хамтарна.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэж, дарамт, мөлжлөгийн бүх хэлбэрээс хамгаалах хуулийн төсөл боловсруулна.

Төрийн удирдах албан тушаалтанд ёс зүй, хүний эрхийн сургалтыг олгох тогтолцоог сайжруулах, ажлын байрны бэлгийн дарамт болон бусад ёс зүйн үндсэн хэм хэмжээ, ёс суртахууны зарчмыг заавал сургаж байж удирдах албан тушаалд томилдог байх соёлыг түгээнэ.

Нийгмийн хамгааллын зорилтот бүлэгт чиглэсэн оновчтой бодлого хэрэгжүүлнэ. Хавтгайсан халамжаас татгалзаж, халамжийг авах шаардлагатай өрх, иргэд рүү

төвлөрүүлнэ. Халамжийн бодлогыг үндэсний үйлдвэрлэлийн бодлоготой уялдуулан хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Чөлөөт хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйг дэмжин хамгаалж, эрүүл, зөв нийгмийн уур амьсгал, харилцааг бүрдүүлэхийг зорино.



## ГУРАВ. ГАДААД ХАРИЛЦАА-ТӨВИЙГ САХИХ ЧИГЛЭЛ БҮХИЙ БОДЛОГО

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйл заасан “Гадаад харилцааны талаарх Ерөнхийлөгчийн бүрэн эрх”-ийн хүрээнд дараах мөрийн хөтөлбөрийг дэвшүүлж байна. Үүнд:**

Мөнхийн хоёр хөрштэй харилцах уламжлалт бодлогыг тууштай баримтлахын зэрэгцээ гуравдах хөршийн бодлогыг шинэ төвшинд гарган эрчимжүүлэх зорилгыг хэрэгжүүлж ажиллана. АНУ, ИБУИНВУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улсуудтай холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлнэ. Гуравдагч хөршөөс орж ирж буй хөрөнгө оруулалтад онцгой анхаарна.

Хөрш орнуудтай гадаад бодлого, гадаад харилцааны тэнцвэрийг барьж ажиллахдаа бодит нөхцөл байдалд зөв дүн шинжилгээ хийж, уян хатан хандаж, прагматик байр суурь баримтлан, Монгол Улс, Монголын ард түмний язгуур эрх ашгийг тэргүүнд тавина. Монгол, Орос, Хятадын гурван улсын Төрийн тэргүүнүүдийн уулзалтыг Улаанбаатарт зохион байгуулах чиглэлээр онцгой анхаарна.

Гадаад бодлогын үзэл баримтлалыг тууштай үргэлжлүүлж, цаг үеийн нөхцөл байдалд зохицсон идэвхтэй байр суурийг баримталж, Монгол Улсын нэр хүндийг дээшлүүлнэ. Хоёр хөрштэйгөө нэн найрсаг, тэнцвэртэй харилцааг эрхэмлэж, гадаад харилцааны цөм нь эдийн засгийн харилцаа гэсэн идэвхтэй байр суурь баримтална.

Гадаад бодлогыг нэг цонхоор хэрэгжүүлэх, төрийн дипломат бодлого залгамж халааг хэлбэрэлтгүй сахина.

Монгол Төрийн гадаад бодлогыг зөвлөн хүчиний аргаар урагшуулахад онцгой анхаарч, энэ талаар боломжит бүх гарц сувгийг ашиглана.

Гуравдагч хөршийн бодлогыг шинэ шатанд гаргаж, гуравдагч хөршийн харилцаанд хоёр хөрштэй адил харилцааг бий болгоо ажиллана. Үүнд АНУ, Япон, Европын Холбоо, Их Британи /ИБУИНВУ/, Энэтхэг, Солонгос, Турк ба бусад гэсэн чиглэлээ урьдын адил мөрдөнө. АНУ, Японтой тогтоосон одоогийн Стратегийн түншлэлийн харилцааг Иж бүрэн стратегийн түншлэлийн түвшинд хүргэнэ.

Монгол Улс ба Европын Холбооны хоорондын харилцааг шинэ шатанд гаргана. Тухайлбал “Шенгений ханыг нураах” уриатайгаар ажиллана. Энэ чиглэлээр ахиц санаачилга гаргаж, Дипломат албыг тулхүү ажиллуулж, 2027 он гэхэд буюу б жилийн дараагаас Монгол Улсын иргэдийг Европын Холбооны гишүүн орнуудад визгүй зорчдог болгох бодлого баримтлан ажиллана.

Төрт ёсны уламжлал, дипломат ёсны түүхэн туршилагаа ашиглан Солонгосын хойгийн асуудлыг энхийн замаар шийдвэрлэх, мөн Ази тивийн тээврийн болон (авто, агаарын чиглэл, төмөр зам гэх мэт) эрчим хүчиний сүлжээнд нэгдэн экспортлогч орон болох зорилтыг тууштай дэмжиж ажиллана.

НҮБ-ын Энхийг сахиулах, мөн НАТО-гийн Энхийг сахиулах, дэмжих ажиллагаануудад урьдын адил Монголын Зэвсэгт хүчин, холбогдох мэргэжилтнийг оролцуулах чиглэлээр үргэлжлүүлэн идэвхтэй ажиллана. Ингэхдээ шинээр илрэх боломж бүрийг гархай ашиглах, Энхийн сахиулах ажиллагаанд Монголын хэвлэл мэдээллийн сэтгүүлчдийг өргөнөөр оролцуулах, Монголд монголчууддаа мэдээлэх чиглэлээр арга хэмжээ авна.

Бүс нутгийн аюулгүй байдал, дэлхий нийтийн энх тайвныг сахин хамгаалахад Монгол Улс хувь нэмэр оруулахыг дэмжиж ажиллана.

Эдийн засаг, гадаад харилцааны бодлого нэгдмэл байж нэг цонхоор хэрэгжинэ. Эдийн засгийн түншлэл, чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг байгуулж, олон улсын хамтын ажиллагааг өргөжуулэн гадаад худалдааг олон тулгууртай болгоно.

Өндөр технологи, аж үйлдвэрлэл, байгаль орчинтой холбоотой гадаад улсуудын хөрөнгө оруулалтыг татах, нээлттэй бүс байгуулах төслийг санаачилж Улсын Их Хурлаар батлуулна.

Дэлхийн монголчуудтай харилцах талаар өмнөх Төрийн тэргүүн нарын эхлүүлсэн ба одоо хэрэгжүүлж буй үйл ажиллагааг хөрш, түнш орнуудтай тогтоосон хоёр талын харилцаанд харшлуулахгүйгээр дэмжиж ажиллана.

Гадаад орнуудад Монгол Улсын хөгжил дэвшил, гадаад харилцаа, гадаадад буй монголчуудын эрх ашигт дэмжлэг үзүүлэхийг бүх талаар анхаарна.

Төрийн тэргүүний хувьд НҮБ-ийн хуралд тогтмол оролцож Монголын байр суурийг идэвхтэй илэрхийлнэ. Гуравдагч хөршийн бодлогыг тууштай баримтална.

Хүний эрхийн болон боловсролын чиглэлийн НҮБ болон бусад нэр хүндтэй олон улсын байгууллагуудын төв, салбарыг Монголд нээх талаар идэвхтэй ажиллана.

Гадаад бодлогын ба гадаад харилцааны сурталчилгааны чиглэлээр Ерөнхийлөгчийн дэргэд шинэ тусгай зөвлөл буй болгож, гадаад сурталчилгааг тасралтгүй, идэвхтэй явуулна.



Нэн ялангуяа энэ 2021 онд тэмдэглэх Үндэсний тусгаар тогтнолын 110 жилийн ой, орчин цагийн Дипломат албаны 110 жилийн ойг ёслол төгөлдөр, гүн утга агуулгатай, нийт ард түмэнд хүртээлтэй арга хэмжээ болгоход онцгой анхаарна.

Хоёр хөрштэйгээ хамтарсан гурван талын уулзалтын бүтцийг сэргээж, бус нутгийн эдийн засаг, соёлын интеграцийг шат ахиулна.

Зүүн Хойд Азийн аюулгүй байдал, дэлхий нийтийн энх тайвныг сахин хамгаалахад Монгол Улс хувь нэмэр оруулах чиглэлээр дэмжиж ажиллана.



## ДӨРӨВ. БАТЛАН ХАМГААЛАХ

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан “Батлан хамгаалах Ерөнхийлөгчийн бүрэн эрх”-ийн хүрээнд дараах морийн хөтөлбөрийг дэвшүүлж байна. Үүнд:**

Мэргэжлийн цомхон чадварлаг армийн бодлогыг хэрэгжүүлэхээс гадна кибер аюулаас хамгаалах мэргэшсэн анги нэгтгэлтэй болох орчин үеийн техник хэрэгслээр хангах ажлуудыг шат дараалтайгаар хэрэгжүүлнэ.

Батлан хамгаалах салбарыг шинэчлэн чадавхжуулж, мэргэжлийн арми иргэний хамгаалалтын хосолмол бодлогыг хэрэгжүүлнэ. Орон нутгийн иргэдэд суурисан хамгаалалтыг бэхжүүлэх, иргэний хяналтын тогтолцоог нэвтрүүлэх замаар салбарын хариуцлагагүй байдлыг арилгана. Уламжлалт бус аюултай тэмцэх бодлогыг шинээр боловсруулан, салбараас тэтгэвэрт гарсан иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд онцгой анхаарна.

Эх оронч үзлийг дэмжиж, цэргийн алба хаах хугацааны сургалтын агуулга, хөтөлбөрийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн сайжруулж, гамшигийн менежментийн сургалтыг зэвсэгт хүчний анги нэгтгэлүүдэд тусгай хөтөлбөр болгож оруулна.

Байгалийн гамшиг, цар тахал, халдварт өвчнийг даван туулах, техник технологи, хүч болон зохион байгуулалтын чадавхыг сайжруулж стратегийн нөөц бүрдүүлэх ажлыг дэмжинэ.

Уламжлалт бус аюул (цар тахал, кибер довтолгоо, хуурамч мэдээ, мэдээлэл г.м)-тай тэмцэх, шинэ төрлийн аюулд хариу өгөх чадвартай бүтцийг бий болгох чиглэлээр хууль санаачилна.

Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн хувьд “Хүчирхэг, Хурдтай Арми” санаачилгын хүрээнд дараах таван шинэчлэлийг эхний 100 хоногт багтаан дараах ажлыг эхлүүлнэ.

1. Зэвсэгт хүчний жанжин штабын дэргэд цэргийн эрх, ашиг сонирхлыг хөндөж байгаа, зөрчиж байгаа аливаа өргөдөл, гомдлыг хүлээн авдаг, армийн сахилга хариуцлагыг сахиулах эрх бүхий цэргийн цагдаагийн албыг (Military Police) шинээр байгуулах санаачилгыг хэрэгжүүлнэ. Энхийн цагт монгол цэргийн амь, эрүүл мэнд хохирох ёсгүй.
2. Энхийг сахиулагчдын олон улсын төвийг Монголд байгуулах замаар эмнэлэг, инженер, дэд бүтэц, өндөр технологийн чиглэлийн хөрөнгө оруулалтыг эх орондоо татах ажлыг санаачлан хэрэгжүүлнэ. Эх орны аль ч цэгт очих чадвартай түргэн байрлах тусгай хүчнийг шинээр эмхлэн байгуулна.<sup>477</sup>
3. Уламжлалт бус аюултай тэмцэх зорилгоор өндөр технологийг кибер халдлагатай тэмцэх судалгаа-үйлдвэрлэлийг жанжин штабын дэргэд байгуулах санаачилга гаргана. Компьютер технологи, математик, физикийн чиглэлийн сургуулиудын оюутнуудыг Оюутан цэрэг хөтөлбөрөөр дамжуулан цэргийн алба хаалгах эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр ажиллана.

## ТАВ. ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан “Үндэсний аюулгүй байдлыг хангах Ерөнхийлөгчийн бүрэн эрх”-ийн хүрээнд дараах мөрийн хөтөлбөрийг дэвшүүлж байна. Үүнд:

Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг тууштай хэрэгжүүлэн ажиллах бөгөөд Монгол үндэстний өөрийн уламжлалт үзэл санааг тууштай хамгаална.

Үндэсний аюулгүй байдалд Монголын улс төрийн намуудын төлөвшил, хөгжил чухал ач холбогдолтойг тэмдэглэн, улс төрийн нам санхүүгийн хувьд ил тод, хариуцлагатай, бодлогын байгууллага болгох шинэчлэлийг эхлүүлэхэд анхаарч улс төрийн намын тухай хууль тогтоомжийн төсөл боловсруулж улс төрийн намууд, иргэний нийгмийн байгууллага, иргэдээр хэлэлцүүлнэ. Засаг захиргааны анхан, дунд шатанд хоосон улс төржилт, талцал хуваагдал асар их байгааг анхааран, үүнийг арилгах үүднээс сум, баг, дүүрэг, хорооны төвшинд улс төрийн намын салбар, нэгж байгуулахыг хязгаарлах эрх зүйн орчныг бүрдүүлэх бодлого боловсруулна.

Ядуурал нь үндэсний аюулгүй байдалд ноцтой эрсдэл үүсгэх үзэгдэл юм. Ядуурлын шалтгаан нь ажилгүйдэл, ажилгүйдлийн шалтгаан нь авлигажсан төр засаг, бизнест халгаатай эрх зүйн тогтвортой орчин гэж үзэн, эдийн засгийг томруулах, хөгжүүлэх нь ядуурал, ажилгүйдэлтэй тэмцэх хамгийн үр дүнтэй арга зам гэдэгт итгэн, улсын хөгжилд нөлөө үзүүлэх том төслүүдээ дэмжих, жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг урамшуулах, хамгаалах бодлого баримтлан ажиллана.

Сүүлийн 25 жилийн хугацаанд нийтийн өмч болох байгалийн баялаг хайх, олборлох үйл ажиллагаа асар их нэмэгдсэн хэдий ч улсын өр өсөн нэмэгдсээр байгаад анхаарлаа хандуулж, Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилт, үр нөлөө, ашигтай байдалд мониторинг хийж, байгалийн баялаг олборлох үйл ажиллагаанд харилцан ашигтай байх зарчмыг хатуу баримтлах бодлогыг санаачлан боловсруулна.

Уул уурхайн салбар дахь авлигыг таслан зогсоох, уул уурхайн баялгаас хүн амын хэт цөөнх илт ашиг хүртэж байгааг зогсоох зорилгоор ашигт малтмал (тухайлбал, нүүрс)-д бүтээгдэхүүн хуваах эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудлыг судлан хуулийн төсөл боловсруулна.



Санхүүгийн зах зээлийн хараат бус, бие даасан байдлыг хангуулж, сайн засаглалыг дэмжинэ.

Эрчим хүчний эх үүсвэрийн бие даасан сүлжээ нь тогтвортой хөгжлийн суурь гэж үзэн, цаашлаад эрчим хүч экспортлогч улс болоход бодлогын дэмжлэг үзүүлэн ажиллана.

Монгол компаниудыг дотоодын жижиг зах зээлд өрсөлдүүлсээр улам жижгэрүүлдэг жишигийг халж, гадагшаа гарч дэлхийн олон улсын зах зээлд тоглогч болгох чиглэлээр төр хувийн хэвшлийн түншлэлийн аливаа бодлогыг бүх талаар дэмжинэ.

Нүүдлийн соёл иргэншлийн салшгүй нэг хэсэг бол бэлчээрийн уламжлалт мал аж ахуй гэж үзэн бэлчээрийн мал аж ахуйн хөгжлийг орчин үеийн эрчимжсэн мал аж ахуйн салбартай зэрэгцэн хөгжүүлэх бодлогыг дэмжинэ. Бэлчээрийн доройтлыг үндэсний аюулгүй байдлын хэмжээнд авч үзэн, бэлчээр ашиглалтын талаарх эрх зүйн орчин, бэлчээрийн зохистой менежментийн төрийн бодлогыг боловсронгуй болгохыг дэмжинэ.

Дэлхийн дулаарал, байгаль орчны өөрчлөлт хүн төрөлхтний оршин тогтонохуйн үндэст нөлөөлж байгааг анхаарч, байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн байнгын өсөлтийг хангасан ногоон эдийн засагт суурилсан хөгжлийн үе шат руу шилжих бодлогыг дэмжиж ажиллана.

Цэвэр усны нөөц сан байгуулах ажлыг олон улсын хөгжлийн хамтын ажиллагаа, төр хувийн хэвшлийн түншлэл зэрэг арга хэрэгслийг ашиглан дэмжиж ажиллана. Шар шорооны аюулыг бууруулах зорилгоор Ногоон хэрэм санаачилгыг олон улсын хамтын ажиллагааны зарчмаар хөхиулэн дэмжинэ. Цэвэр усны сан байгуулах, ойжуулах ажлыг нэг удаагийн төсөл хөтөлбөр төдий биш харин хөдөө орон нутагт тогтвортой ажлын байр бий болгох ногоон эдийн засгийн шинэ салбар гэж үзнэ.

Био аюулгүйн гуравдугаар зэрэглэлийн “лаборатори”-ийг ашиглалтад оруулж, цар тахал, шинэ вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх нөхцөлийг яаралтай бүрдүүлэх санаачилгыг гаргана.

Шашныг философи утгаар нь шинэчлэн хөгжүүлэх санаачилгыг дэмжинэ.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг чадавхжуулна. Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн тэргүүний хувиар дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

1. Үндэсний Аюулгүй байдлын Зөвлөлийн эрх үүрэг, бүтцийг шинэчлэх хуулийг Улсын Их Хуралд өргөн барина. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүдийг аливаа Үндсэн хуулийн бус санал санаачилга гаргах, хуулийн болон санхүүгийн нэмэлт эрх мэдэл (хонгил) Үндэсний аюулгүй байдалд олгохыг хориглосон хуулийн төслийг санаачилна.
2. Онцгой байдлын тогтолцоо, үйлчилгээг иргэдэд түшиглэсэн, иргэдийн оролцоог хангасан байдлаар шинэчлэх бодлогыг санаачилна Иргэн өөрөө өөрийгөө хамгаалах, бусдад энэ туслалцаа үзүүлэх гамшиг, цар тахлаас хамгаалах үндэсний тогтолцоог буй болгох бодлогыг дэмжинэ.
3. Ерөнхийлөгч тусгаар тогтиол, гадаад бодлоготой холбоотой аливаа асуудлаар хувийн байр суурь илэрхийлэхийг хориглоно.

Монгол Улс нь Авлигын эсрэг олон улсын конвенцод нэгдээд даруй 16 жил, Авлигын эсрэг хуулийг батлан хэрэгжүүлээд даруй 15 жил өнгөрсөн хэдий ч авлига буурах нь бүү хэл, хүрээгээ тэлэн нэмэгдсээр байгаа нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, нийгмийн тогтвортой хөгжил, ардчилсан тогтолцоо, үнэт зүйлс, ёс суртахуун, шударга ёс, тэгш байдал, тогтвортой хөгжилд илтэд, бодитой хохирол, аюул учруулж байгааг цохон тэмдэглэн, **АВЛИГА** нь Үндэсний аюулгүй байдалд ноцтой заналхийлсэн **ДАЙСАН** гэж олон нийтэд зарлан, авлигатай тэмцэх стратеги, бодлогыг ахисан төвшинд хүргэнэ. Үүний хүрээнд авлигын эсрэг дараах ажлыг санаачилна: Үүнд:

1. Төрийн өндөр албан тушаалтнуудын тухайд их хэмжээгээр гэнэт нэмэгдсэн хөрөнгө, орлогын мэдуулэг, түүний эх сурвалжийг зөвхөн Авлигатай тэмцэх газарт тайлагнаж байгааг учир дутагдалтай гэж үзэн хөрөнгө, орлогын эх үүсвэрээ олон нийтэд тайлагнах эрх зүйн орчныг бий болгох,
2. Сонгогчдыг хуурч, сонгогчдын итгэлийг алдсан Улсын Их Хурлын гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татах хууль санаачлах,
3. Ил тод байдал, олон нийтийн хяналт нь авлигаас урьдчилан сэргийлэх хамгийн чухал хөшүүрэг гэж үзэн Шилэн дансны тухай хууль, мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомж зөрчсөн удирдах албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчныг бүрдүүлэх,
4. Авлигын нэг эх уурхай гэж шүүмжлэгдэх болсон улс төрийн намууд, түүний санхүүжилт, сонгуулийн зардлыг ил тод болгох, төрөөс өгөх дэмжлэгийг иргэдийн өгсөн саналд үндэслэн тэгш хуваарилах тогтолцоог боловсронгуй болгох, Энэ чиглэлээр нийгмийн том хэлэлцүүлэг өрнүүлж, даацтай шийдлийг иргэдтэй хамт олж, бодлого боловсруулах,
5. Авлигатай тэмцэх газрын соён гэгээрүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг салгах эрх зүйн орчин бүрдүүлэх,

6. Авлигын шалтгаан, эх үүсвэр, сурвалж нь шударга бус, тэгш бус, тодорхой бус, хуулийн цоорхой гэж үзэн авлигад хамгийн ихээр нэрвэгдэж байгаа салбарын хууль тогтоомжийг ардчилсан ёс, шударга ёс, тэгш байдалд нийцүүлэн өөрчлөх үйл ажиллагааг иргэд, хуулийн этгээдтэй хамтарч зохион байгуулах,
7. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах харилцаа нь авлигад хамгийн ихээр өртсөн салбарын нэг гэж, үзэн энэ салбарт шударга өрсөлдөөн бий болгох замаар тендерийн авлигыг устгах эрх зүйн орчныг бүрдүүлэх,
8. Авлигатай үр дүнтэй урьдчилан сэргийлж тэмцэхэд дан гарын Авлигатай тэмцэх газрын тэмцэл хангалтгүй гэж үзэн, авлигын эсрэг тэмцэлд олон талт хандлага, иргэн, хуулийн этгээд, иргэний нийгмийн байгууллага, олон нийтийн оролцоог эрс нэмэгдүүлэх бодлого боловсруулах.
9. Авлига, албан тушаалын гэмт хэргийн эсрэг шүгэл үлээгчдийг хамгаалж, дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх.

## ЗУРГАА. БУСАД АСУУДАЛ

Ерөнхийлөгчийн эхний 100 хоногт дараах хуулиудыг санаачилж, УИХ-д өргөн барина.  
Үүнд,

- Хамтын тэтгэврийн тухай хуулийн төсөл
- “Иргэний асуулга асуух эрх”-ийг баталгаажуулж, төрийн байгууллага бүр жил бүр иргэд, салбарын аж ахуйн нэгж, мэргэжилтнүүдэд хөрөнгө зарцуулалтын болон үйл ажиллагааны тайлангийн сонсгол хийдэг байх хуулийн төсөл
- Хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах хуулийн төсөл (Ардчилсан нийгмийн дөрөвдөгч засаглал гэгдэх хэвлэлийн эрх чөлөөний баталгааг дээшилүүлж, хэвлэлийн мэдээллийн эрх чөлөөгөө өдэлсний төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг жишгийг хална)
- Баг, хорооны удирдлагын талаарх хуулийн төсөл (Баг, хорооны Засаг даргыг дээд шатны Засаг даргад санал болгох, ИТХ-ын даргыг бүх иргэдийг тэгш оролцуулах үүднээс нийт иргэдээс сонгуулийн журмаар сонгох хуулийн төсөл)
- Иргэний төрийн үйлчилгээ авах тогтолцоог шинэчлэх хуулийн төсөл (Иргэн нь иргэний бүртгэл, нийгмийн даатгал, эрүүл мэнд, татвар зэрэг төрийн үйлчилгээг нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгж харгалзахгүйгээр авах)
- Сонгогдсон, томилогдсон төрийн өндөр албан тушаалтан нь ёс зүйн зөрчил гаргасан бол олон нийтээс учлал гүйх үүргийг хуульчилж, түүнийг огцруулах, чөлөөлөх хууль эрх зүйн үндэслэлийг тодорхой болгох бие даасан хуулийн төсөл

7. Цэргийн албанд иргэний хяналтыг нэмэгдүүлэх хуулийн төсөл (Зэвсэгт хүчний жанжин штабын дэргэд иргэний эрх, гомдлыг хүлээн авдаг, армийн сахилга хариуцлагыг сахиулах эрх бүхий цэргийн цагдаагийн албыг шинээр байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх)
8. Төрийн тод байдлыг сайжруулах хуулийн төсөл (Ил тод байдал, олон нийтийн хяналт нь авлигаас урьдчилан сэргийлэх хамгийн чухал хөшүүрэг гэж үзэн Шилэн дансны тухай хууль, мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомж зөрчсөн удирдах албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэх)
9. Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох тухай хуулийн төсөл (мөнгө хүүлэлтийн эсрэг, харилцагчийн эрх ашгийг хамгаалах олон улсын сайн жишигт нийцүүлэх).

АРДЧИЛСАН НАМ

8488916 ХНТ4896  
УЛААНБААТАР ХОТ

